



ТАНИЛЦУУЛГА

“Тогтвортой ноолуур” холбоо нь AVSF Монгол буюу Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид байгууллагын дэмжлэгтэйгээр Баянхонгор аймгийн тогтвортой ноолуур бэлтгэгч хоршоодын санаачилгаар 2017 онд байгуулагдсан ашгийн бүс, гишүүдэд үйлчилдэг төрийн бүс байгууллага.

Холбоо нь хоршоодыг зах зээлтэй холбох маркетингийн үйл ажиллагааг зохион байгуулж, малчдын байгальд ээлтэй аргаар бэлтгэж, боловсруулсан түүхий эдийг Европын зах зээлд нэмүү өртгөөр борлуулахад дэмжлэг үзүүлдэг.

ЗОРИЛГО

“Тогтвортой ноолуур” холбоо нь хоршоодын үйл ажиллагааг эрчимжүүлж, байгальд ээлтэй аргаар хоршоодын бэлтгэсэн түүхий эдийг олон улсын зах зээлд гаргах замаар малчдын амьжиргааг дээшлүүлж, байгаль орчинг хамгаалахад хувь нэмэр оруулах зорилготой.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Тогтвортой ноолуур” холбоо нь түүхий эд буюу ноолуурын нэмүү өртгийн сүлжээний эхний хэсэг буюу малчдын хоршоодод тогтвортой ноолуур бэлтгэлийн сайн туршлагыг нэвтрүүлж, зөв дадлыг төлөвшүүлж, эх үүсвэр нь тодорхой, мөшгөх боломжтой бэлтгэн, нийлүүлэлтийн загварыг нэвтрүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг. Холбооны гишүүн хоршоод AVSF Монгол байгууллагын санаачлан нэвтрүүлсэн Тогтвортой ноолуур гэрчилгээжүүлэлтийн схемд бүрэн хамрагддаг.

Мөн AVSF Монгол байгууллагын дэмжлэгтэйгээр малын үржил, эрүүл мэнд, ноолуурын чанарыг сайжруулах тал дээр тогтмол анхаардаг тул ноолуурын чанарын хувьд олон улсын худалдан авагчдын шаардлагыг бүрэн хангадаг. 2017 оноос хойш Холбоо нь гишүүн хоршоодын бэлтгэсэн тогтвортой ноолуурын борлуулалтыг зургаа дахин нэмэгдүүлээд байна.

Түүнчлэн хоршоодын малчдын нийгмийн асуудлыг сайжруулах зорилгоор гадны хандивлагч байгууллагын тусламжтайгаар эрүүл мэнд, боловсролд чиглэсэн хөтөлбөрүүдийг жил бүр үр дүнтэйгээр хэрэгжүүлдэг.

“ТОГТВОРТОЙ НООЛУУР” ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

Холбооны гишүүдийн бэлтгэдэг ноолуурын баталгаа нь 25 шалгуур бүхий “Тогтвортой ноолуур” гэрчилгээжүүлэлт юм.

2021 оны байдлаар нийт гишүүдийн 85% нь аймгийн болон үндэсний хэмжээний Гэрчилгээжүүлэлтийн хороодоор шалгагдаж, баталгаажсан “Тогтвортой ноолуур” гэрчилгээтэй.


Гэрчилгээ авсан малчин, малчдын хоршоо нь тогтвортой ноолуур бэлтгэн нийлүүлэх нэмүү өртгийн сүлжээний нэг хэсэг болж, гадаадын зах зээлд нэвтрэх боломжтой болохоос гадна, үндэсний хэмжээний тогтвортой үйлдвэрлэлд хувь нэмрээ оруулах анхан шатны нэгж хэмээн хүлээн зөвшөөрөгдөх боломжтой юм.

ТОГТВОРТОЙ НООЛУУР ХОЛБООНЫ ХАМТРАГЧ ТАЛУУД

- Баянхонгор, Хэнтий, Архангай, Завхан, Говь-Алтай аймгийн ЗДТГ, ХХААГ, Мал эмнэлгийн газар
- Сумдын удирдлага, мэргэжилтнүүд
- Монголын үндэсний хоршоологчдын Холбоо
- Бэлчээр ашиглагчдын хэсгүүд
- Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн Холбоо
- Зарим боловсруулах үйлдвэрүүд



ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРУУД:



ТОГТВОРТОЙ НОЛУУРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ:

Тогтвортой ноолуур хэмээх ойлголт тогтвортой хөгжлийн зарчимд тулгуурласан бөгөөд байгальд ээлтэй, нийгэмдээ тэгш хүртээмжтэй, эдийн засгийн хувьд алдагдалгүй аргаар үйлдвэрлэсэн түүхий эд юм.



Байгаль орчны ач холбогдол байгаль орчинд сөрөг нөлөөгүй, эсвэл бага нөлөөтэй/байгаа байдлыг доройтуулахгүй байх



Нийгмийн ач холбогдол - малчин гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалж, нийгмийн сайн сайхан, тааламжтай, баталгаатай байдал хангагдсан байх;



Эдийн засгийн ач холбогдол - эдийн засгийн өсөлт тэгш хангагдаж, ашиг орлогын шударга хуваарилалттай байх.

“ТОГТВОРТОЙ НОЛУУР” ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

Тогтвортой ноолуур холбоо нь Баянхонгор, Архангай, Хэнтий, Завхан, Говь-Алтай аймгийн 14 хоршооны нийт 1000 орчим өрхийн 3500 гаруй малчны гишүүнчлэлтэй бөгөөд цаашид бид тогтвортой ноолуур бэлтгэлийн сайн туршлагаа бусад аймаг, сумдад өргөжүүлэхээр ажиллаж байна.

Баянхонгор аймаг:

- Богд сумын “Орог нуурын хишиг” хоршоо
- Жинст сумын “Түйн хишиг” хоршоо
- Бөмбөгөр сумын “Өгөөж Баян Өлзийт Гол” хоршоо
- Баян-Өндөр сумын “Идрэнгийн цагаан сувд” хоршоо
- Баянцагаан сумын “Баянгичгэнэ” хоршоо

Архангай аймаг:

- Эрдэнэбүлган сумын “Ар арвижин дэлгэрэх” хоршоо
- Цэцэрлэг сумын “Шинэ Зуун хонгорж” хоршоо
- Жаргалант сумын “Өрнөн дэлгэрэх элгэд” хоршоо

Хэнтий аймаг:

- Биндэр сумын “Өгөөж баян Биндэрьяа” хоршоо
- Мөрөн сумын “Мөнх Мандах Мөрөн” хоршоо

Завхан аймаг:

- Алдархаан, Дөрвөлжин сумдын “Шимт мандалын өгөөж” хоршоо

Говь-Алтай аймаг:

- Дарви сумын “Баян-Ундрал” хоршоо

ХОЛБОО БАРИХ :

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сөүлийн гудамж, МЖЖ байр, 4-р давхар, 405 тоот
Утас: +976 70123868; +976 80603868
Имэйл хаяг: info@sustainablecashmere-mongolia.com

Facebook хуудас: Sustainable Cashmere Union Цахим хуудас: sustainablecashmere-mongolia.com

www.avsfmongolia.org

1000
өрх



3500
малчин



85%



аймгийн болон үндэсний хэмжээний Гэрчилгээжүүлэлтийн хороодоор шалгагдаж, баталгаажсан “Тогтвортой ноолуур” Гэрчилгээтэй.

